



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 07 өдөр

Дугаар 1/02

Улаанбаатар хот

Тэмцээн зохион байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Монгол Улсын биеийн тамир, спортын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын аварга шалгаруулах 2 төрөлтийн тэмцээнийг 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Давтан сургалт сэргээн заслын төв 113 дугаар ангийн сургалтын талбайд зохион байгуулсугай.

2. Тэмцээн зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, бэлтгэл ажлын төлөвлөгөө, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, шаардагдах зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээнд шаардагдах 1,237,872 (нэг сая хоёр зуун гучин долоон мянга найман зуун далан хоёр) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү, Эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

4. Тэмцээнд оролцох баг, тамирчдын сахилга бат, дэг журмыг сахиулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийг мөрдөж, бэлтгэлийг хангуулж оролцуулахыг дүүргийн Онцгой байдлын хэлтэс, нийслэлийн Аврах анги 105-ын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Тэргүүн дэд дарга (хурандаа Н.Нямхорлоо)-д даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА



Ж.ЧҮЛТЭМСҮРЭН

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2020 оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Тэмцээний зорилго

Гал түймэртэй тэмцэх байгууллага үүсэж хөгжсөний 98 жилийн ойг тохиолдуулан, алба хаагчдын биеийн тамир спорт, бие бялдрыг хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд оршино.

Хоёр. Тэмцээний төрөл, хугацаа

Ойн арга хэмжээний хүрээнд "Хөл бөмбөг", "Олс таталт" гэсэн 2 төрлөөр Онцгой байдлын ерөнхий газрын харьяа "Жаргалант" давтан сургалт сэргээн заслын төвд 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 10:00 цагт зохион байгуулна.

Гурав. Оролцох багууд:

1. Нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймэртэй тэмцэх хэлтэс
2. Дүүргүүдийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах аврах, анги бүрээс 1 баг,
3. Нийслэлийн Аврах анги 105,
4. Гамшгаас хамгаалах сургалтын төв зэрэг нийт 18 баг оролцоно.

Дөрөв. Тэмцээний зохион байгуулалт

"Хөл бөмбөг"-ийн тэмцээн /нийт 6 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй/

- Дүүргүүдийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах аврах, ангийн багийн бүрэлдэхүүнд хэлтсийн бүрэлдэхүүнээс офицер 1, ангийн захирагч 1, салааны захирагч 1, жолооч 1, гал сөнөөгч 1, оператор 1,

- Нийслэлийн Аврах анги 105-ийн багийн бүрэлдэхүүнд ангийн захирагч 1, мэргэжилтэн, эмч 1, бүлгийн дарга 1, жолооч 1, аврагч 1, оператор 1,

- Гамшгаас хамгаалах сургалтын төвийн багт Төвийн дарга 1, багш 5 /1 эмэгтэй албан хаагчтай/

Тэмцээнд оролцох багууд 1 дүгээр үед сугалааны дарааллаар хасагдах журмаар, 2 дугаар үед үлдсэн 9 баг 3 хэсэгт /А, В, С/ хуваагдаж зоондоо тойргоор тоглож хэсгээс 1 баг тус бүр шалгарч, 3 дугаар үед хэсгээс шалгарсан багууд тойргоор тоглож 1 дүгээр байрны төлөө өрсөлдөнө. Аваргын төлөөх тоглолтонд багуудын хожил тэнцсэн тохиолдолд шигшээ тоглолтоор олон бөмбөг оруулсан баг хожно.

Заалны хөл бөмбөгийн үндсэн дүрмээр тоглох бөгөөд талдаа 6 минут, нийт 12 минут тоглож, оноо тэнцвэл талууд тус бүр торгуулийн 3 цохилтыг эзлжлэн хийж, хэн олон бөмбөг оруулсан нь хожно. Тоглолт хоорондын завсарлага 2 минут байна.

"Олс таталт"-ын тэмцээнд эрэгтэй 5 алба хаагч, эмэгтэй 1 алба хаагч нийт 6 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй оролцоно.

- Дүүргүүдийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах аврах, ангийн багийн бүрэлдэхүүнд хэлтсийн бүрэлдэхүүнээс офицер 2, салааны захирагч 1, жолооч 1, гал сөнөөгч 1, оператор 1,

- Нийслэлийн Аврах анги 105-ийн багийн бүрэлдэхүүнд мэргэжилтэн, эмч 2, бүлгийн дарга 1, жолооч 1, аврагч 1, оператор 1,

- Гамшгаас хамгаалах сургалтын төвийн багт багш, алба хаагч 5 /1 эмэгтэй алба хаагчтай/

Тэмцээнд оролцох багууд 1 дүгээр үед сугалааны дарааллаар хасагдах журмаар, 2 дугаар үед үлдсэн 9 баг сугалааны дарааллаар 1 баг гоц мөргөж 8 баг хоорондоо хасагдах журмаар, 3 дугаар үед хэсгээс шалгарсан 5 баг сугалааны дарааллаар 1 баг гоц мөргөж 4 баг хоорондоо хасагдах журмаар, аваргын төлөө 3 баг тойргийн журмаар өрсөлдөнө.

- Техникийн зөвлөгөөнийг 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 14:00 цагт нийслэлийн Онцгой байдлын газрын Соёлын төвд явагдана.
- Нийслэлийн Онцгой байдлын газар шүүгч болон шаардлагатай техник хэрэгслийг хариуцан ажиллана.
- Багийн ахлагч нар Техникийн зөвлөгөөн дээр тамирчдын мэдүүлгийг өгч оролцоно.
- Баг тамирчид ижил өнгийн хувцсаар жигдэрнэ.
- "Хөл бөмбөг", "Олс таталт"-ын тэмцээн зэрэг явагдах тул дасгалжуулагч баг тамирчдаа зөв хуваарилах,
- Ангийн захирагч, багийн дасгалжуулагч нар Баг тамирчдыг багийн хаягтай, нээлт хаалтын үйл ажиллагаанд сахилга, дэг журмыг хангуулан оролцуулж, согтууруулах ундаа хэрэглэхийг хатуу хориглоно.

Тав: Шалгаруулах журам, шагнал урамшуулал.

Хөл бөмбөгийн төрөлд

- 1-р байр өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал, шилжин явах цом,
- 2-р байр өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал
- 3-р байр өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал

Олс таталтын төрөлд

- 1-р байр өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал
- 2-р байр өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал
- 3-р байр өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал

---oOo---

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2020 оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн
2/92 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН АЛБА ХААГЧДЫН ДУНД
ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ТЭМЦЭЭНИЙ БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Хийгдэх ажлууд	Хариуцах эзэн	Тайлбар
Нээлтийн арга хэмжээний бэлтгэл хангуулах			
1	Тэмцээн явуулах газар цэвэрлэгээ хийлгэх, тоног төхөөрөмжийг байршуулах	Дэд хурандаа Ж.Алтанхуяг, Ахмад О.Мөнхбат, ГТУА-30 дугаар анги дэд хурандаа Т.Батжаргал	Гал түймэр унтраах, аврах ангиуд
2	Радио станцуудыг бэлтгэх /5 ширхэг/	Ахлах дэслэгч З.Мөнх-Од	Радио станцуудыг цэнэглэж, бэлтгэх
3	Хэв журам сахиулах хяналт тавьж ажиллах	Хошууч Ж.Төмөрмандах Ахмад Ц.Чинзориг Ахмад Ч.Батболд	Алба хаагчдын сахилга, ёс зүй, дэг журмыг сахиулж, хяналт тавьж ажиллах
4	Ёс журмын эргүүлийн таних тэмдэг, энгэрийн зүүлт тавиулангийн зохицуулагчийн дохиур, хантааз бэлтгэх	Дэслэгч Д.Батболд Ахлах ахлагч Э.Хандармаа	Ёс журмын эргүүлийн тэмдэг, зохицуулагчийн дохиур бэлтгэх
5	Хөл бөмбөгийн 2 мэргэжлийн шүүгч оролцуулах	Ахлах дэслэгч Н.Төрбат	Хөл бөмбөгийн холбоотой холбогдож тохиролцох /санхүү/
Шаардлагатай зүйлсийг хангуулах			
6	Хулдаасан хэвлэл бэлтгэх, хэвлүүлэх, байрлуулах	Ахмад О.Мөнхбат, Ахмад Б.Баатар, Дэслэгч Э.Эрдэнэбаатар	Эх загварыг бэлтгэж, хянуулж батлуулах
7	Өргөмжлөл, медалийн бичилт хийлгэх		Загвар, үнийн саналыг танилцуулах
8	Узель, дефузор, уртасгагч, микрофон, цахилгаан үүсгүүр бэлтгэх	Ахмад З.Мөнх-Од	Тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах, мотор бэлтгэх
9	Чанга яригч-1ш /зөөврийн болон чихэвчтэй/	Ахлах дэслэгч Л.Батсайхан	
10	Арга хэмжээнд үйлчлэх автомашины бэлэн байдлыг хангах	Ахмад Б.Сэрдамба	Бензин шатахууныг шийдвэрлэж, автомашинаар үйлчлэх
11	Иштэй туг /улаан-8ш, шоотой эрээн-2ш/	Хошууч О.Дамдинсүрэн, Ахлах ахлагч Э.Хандармаа	Шаардлагатай тоогоор бэлтгэх, дутууг нэмж бэлтгэх
12	Цаг хэмжигч-2ш /Секундомир/, 3 шүгэл		Найдвартай хэвийн ажиллагааг шалгах
13	Эмнэлгийн анхны тусламжийн цүнх, насилька, бэлтгэх	Дэд хурандаа Ж.Алтанхуяг Дэслэгч Б.Анар	НАА-105-аас эмнэлгийн машин гаргах
14	Майхан, гэр ачих, буулгах, барих, бусад эд хогшил зөөх	Захиргааны удирдлагын хэлтэс	Автомашин бэлтгэж хүн хүчээр хангах
15	Хөл бөмбөгийн тэмцээний хаалга зөөж байрлуулах	Хошууч Б.Мягмаржав, НАА-105-ын Штабын дарга, ахмад Ж.Дамбадаржаа	"Аврагч" спорт хороо, ЕБС-аас нийт 4 хөл бөмбөгийн хаалга шийдвэрлэх
16	Олс таталтын тэмцээнд	Хошууч Р.Мөнхбат	"Аврагч" спорт хороо,

	ашиглагдах олсыг бэлтгэх		ЕБС-аас нийт 2 зориулалтын олс шийдвэрлэх
17	Зочид, тэмцээнд оролцож байгаа болон шүүгчдийг хоол цайгаар хангах	Санхүү, эдийн засгийн хэлтэс	Хооллох албан хаагчдын тоог гаргаж хоол цай хийх үйлчлэх албан хаагчдыг томилох
18	Нисгэгчгүй төхөөрөмжөөр бичлэг хийх /дрон/	Ахмад Б.Баатар	Нисэх төхөөрөмжийг бэлтгэх, батарей цэнэглэж бэлэн болгох, зураг авах
19	Бичлэг хийх	Дэслэгч Б.Алпамыс	
20	Зураг авах		
Хөл бөмбөгийн тэмцээний шүүгч			
21	Ерөнхий шүүгч	Хурандаа Н.Нямхорлоо	
22	Шүүгч	Ахмад Б.Сэрдамба	
23	Шүүгч	Ахмад Г.Батмөнх	
24	Шүүгч	Дэслэгч Т.Батбаатар	
25	Шүүгч	Ахмад З.Мөнх-Од	
26	Шүүгч	Дэслэгч Э.Оргил	
Олс таталтын тэмцээний шүүгч			
27	Ерөнхий шүүгч	Дэд хурандаа Э.Эрдэнэбаатар	
28	Шүүгч	Хошууч Р.Мөнхбат	
29	Шүүгч	Дэд хурандаа Ч.Гансүх	
30	Шүүгч	Хошууч Ц.Гантулга	
Тэмцээний хаалтын ажиллагаанд бэлтгэл хангуулах			
31	Дадлага сургуулийн ерөнхий дүнг нэгтгэж гаргах	Дэд хурандаа Д.Одонбаяр Дэслэгч Ө.Мөнх-Отгон	Шаардлагатай зүйлсийг бэлтгэх
32	Шагнал гардуулах /медаль, өргөмжлөл, цом, мөнгөн шагнал/	Ахлах ахлагч Б.Шинэтунгалаг, Ахлах ахлагч Б.Халиунцэцэг, Энгийн Д.Гүнсэнхорол	Хээрийн хувцас, ширээ, дугтуй, тавиур, шагналыг бэлтгэх
Тэмцээн зохион явуулах бэлтгэл хангуулах			
33	Техникийн зөвлөгөөнийг зохион байгуулах	Хурандаа Д.Мөнхсайхан	Хийгдэх ажлын нэг бүрчлэн хариуцаж хийх
34	Тамирчдын аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Хурандаа Д.Мөнхсайхан, Багийн дасгалжуулагч	

---oOo---

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн
d/02 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



ХӨЛБӨМБӨГ, ОЛС ТАТАЛТЫН" АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Медаль	ш	42	8000	336.000
2	Цом	ш	1	40.000	40.000
3	Өргөмжлөлийн жааз	ш	6	4.000	24.000
4	Аннонс /6 х 4 метр/	м/кв	1	24x12.00	288.000
5	Аннонс /6 х 0.5 метр/	м/кв	1	3*12.00	36.000
6	Зочид төлөөлөгч, Шүүгчдийн хоол	хүн	30 хүн	12.000	360.000
7	Шатахуун	лирт	65.2	2360	153.872
Бүгд дүн					1,237,872.00

---oOo---